



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Заавар шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.1.2 дахь заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Сэтгэл зүйн ажлын заавар"-ыг нэгдүгээр, хоригдлын сэтгэл зүйг тодорхойлох, үйлчилгээ үзүүлэх мэдээллийн санг бүрдүүлэх маягт, бүртгэлийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга /хурандаа Ш.Булган/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/106 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА, ХУРАНДАА

Д.ДАМДИНЦЭРЭН



СЭТГЭЛ ЗҮЙН АЖЛЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сэтгэл зүйч нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хорих ангийн дотоод журам, сэтгэл зүйчийн ёс зүйн дүрэм болон энэхүү зааврыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү зааврын зорилго нь хоригдол, хоригдсон болон баривчлагдсан этгээд /цаашид "хоригдогч" гэх/-ийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн мэргэжлийн үйл ажиллагааны дараалал, арга, хэлбэр, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлж, сэтгэл зүйчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.3. Сэтгэл зүйч гэж хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг хэлнэ.

1.4. Энэ зааварт заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. "Сэтгэл зүйн байдал" гэж хоригдогчийн зан үйл, сэтгэл зүйн хувийн онцлогыг;

1.4.2. "Зан үйл" гэж хүрээлэн байгаа орчинтойгоо харилцан холбоотой, нийгмийн шинжтэй, ухамсартай, зориудын, зорилго чиглэлтэй үйл ажиллагааг;

1.4.3. "Сэтгэл зүйн хувийн онцлог" гэж бие биеэс нь ялгах хүний сэтгэцийн процесс, сэтгэцийн шинж, сэтгэлийн байдлын өвөрмөц онцлогыг;

1.4.4. "Сэтгэцийн шинж" гэж тодорхой хүний сэтгэц, ухамсрыг илэрхийлэх, харьцангуй тогтвортой чанарыг; /Сэтгэцийн шинжид зан төлөв, темперамент, сэтгэлийн хөдөлгөөн, авьяас, сонирхол, хандлагыг хамааруулж ойлгоно/

1.4.5. "Сэтгэл зүйн зөвлөгөө" гэж хоригдогч сайн дурын үндсэн дээр өөрийн нөхцөл байдлаа ойлгож, сэтгэл зүйн тулгамдсан асуудлаа тодруулах, бэрхшээлийг давах, шаардлагатай үед нөхцөл байдлаа өөрчлөхөд нь туслах дэмжлэг үзүүлэх хамтын ажиллагааг;

1.4.6. "Сэтгэл зүйн тулгамдсан асуудал" гэж нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг;

1.4.7. "Сэтгэл зүйн тодорхойлолт" гэж хувь хүний онцлогыг багтаасан зан байдал, бие хүний онцлог шинж, харилцаа, зан үйлд гарч буй өөрчлөлт, ажиглалт, судалгааны үр дүнд хуримтлуулсан дүгнэлтийг;

Хоёр. Сэтгэл зүйчийн ажлын үндсэн чиг үүрэг

2.1. Хорих ангийн сэтгэл зүйч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Хоригдлоос сэтгэл зүйн судалгаа авах;

2.1.2. Хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлох;

2.1.3. Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх;

2.1.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулна;

2.2. Цагдан хорих байрны сэтгэл зүйч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.1. Хоригдогчоос сэтгэл зүйн судалгаа авах;

2.2.2. Хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох;

2.2.3. Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх;

2.2.4. Хоригдогчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж үр дүнгийн талаар холбогдох албан тушаалтанд танилцуулах;

2.3. Баривчлах төвийн сэтгэл зүйч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.1. Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай баривчлагдсан этгээдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч үр дүнгийн талаар удирдлагад танилцуулах;

2.3.2. Баривчлагдсан этгээдийн сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх;

2.3.3. Албадан сургалтыг нийгмийн ажилтан, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.4. Цагдан хорих байранд сэтгэл зүйчийн ажил үүргийг албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай алба хаагчаар гүйцэтгүүлнэ.

Гурав. Сэтгэл зүйн судалгааны төрөл

3.1. Сэтгэл зүйч нь хоригдогчийн сэтгэл зүйн хувийн онцлог, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг тодруулах зорилгоор доорх судалгаанаас 5 хүртэлх судалгааг сонгон дүгнэлт гаргана.

3.1.1. Түгшүүрийн илрэлийг тодорхойлох; /GAD-7/

3.1.2. Сэтгэл гутралын түвшинг тодорхойлох; /PHQ-9/

3.1.3. Зан төлөвийн хурцдалыг тодорхойлох Леонгардын судалгаа;

3.1.4. Темпераментийн судалгаа;

3.1.5. Бие хүний 16 хүчин зүйлт асуулга;

3.1.6. Дасан зохицох чадварыг тодорхойлох судалгаа;

3.1.7. Үнэт зүйлсийн баримжаа;

- 3.1.8. Насанд хүрэгчдийн оюун ухааны чадамжийг тодорхойлох судалгаа;
- 3.1.9. Аудит асуумж;
- 3.1.10. Проектив тест;
- 3.1.11. Дуусгаагүй өгүүлбэрийн арга;

3.2. Дээрх судалгааг хоригдогчид илрэх зан үйлээс шалтгаалан дахин авч, эерэг, сөрөг өөрчлөлтийг үнэлж холбогдох сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлнэ.

3.3. Хоригдогчийн хувийн онцлогоос хамаарч нэмэлтээр баталгаат сэтгэл зүйн сорил судалгааг авч болно.

Дөрөв. Сэтгэл зүйн байдлыг тодорхойлох

4.1 Сэтгэл зүйн байдлыг дараах байдлаар тодорхойлно.

- а. Ярилцлага хийх;
- б. Ажиглалт хийх;
- в. Сэтгэл зүйн сорил судалгаанд хамруулах;
- г. Алба хаагчдаас авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх

4.1.1. Шинээр болон шилжин ирсэн хоригдогчтой анхны уулзалтыг хийж, тэмдэглэл хөтлөх;

4.1.2. Хоригдогчтой холбоотой бичиг баримт, хувийн хэрэгтэй танилцан мэдээлэл цуглуулах;

4.1.3. Сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх анхан шатны судалгааны үр дүнгийн талаар илтгэх хуудсаар ангийн удирдлагад танилцуулах;

4.1.4. Хоригдогчид тулгарч буй сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт уулзалтыг зохион байгуулна.

4.1.5. Төлөвлөгөөт уулзалтыг товлосон хугацаанд нь заавал хийж, тэмдэглэл хөтөлсөн байна.

4.1.6. Хоригдогчийн сэтгэл санаа хямарч тогтворгүй болох, эрсдэлт зан үйл илэрсэн тохиолдолд төлөвлөгөөт уулзалтыг хугацаанаас өмнө зохион байгуулж болно.

Тав. Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх

5.1. Хоригдогчид итгэл үнэмшил өгч, баталгаа үзүүлэх зорилгоор сэтгэл зүйн зөвлөгөөний гэрээ байгуулах ба гэрээнд сэтгэл зүйч болон хоригдогчийн оролцоо, хувь хүний нууцыг хадгалах асуудлыг тусгаж гарын үсэг зурж баталгаажуулна.

5.2. Хоригдогчийн яриаг анхааралтай сонсон, асуултыг оновчтой тавьж яриаг чиглүүлэн, хариултанд дүн шинжилгээ хийнэ.

5.3. Хоригдогчийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллаж болно.

5.4. Хоригдогчийн сэтгэл зүйд эерэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдсэн сэдэлд нь тохирсон дор дурдсан сургалтуудаас сонгон хэрэглэнэ.

5.4.1. Уур бухимдлаа зохицуулах;

- 5.4.2. Харилцааны ур чадвараа сайжруулах;
- 5.4.3. Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- 5.4.4. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;
- 5.4.5. Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх;
- 5.4.6. Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх;
- 5.4.7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх;
- 5.4.8. Богино хугацааны трейнинг, дасгал, бясалгал;

5.5. Хоригдогчийн хэрэгцээнд суурилсан хувь хүний хөгжлийг дэмжих эерэг мэдээллээр хангахын тулд тусгайлан бэлтгэсэн сургалтын нэвтрүүлгийг зурагт, проектор, гарын авлага ашиглан төрөл бүрийн хэлбэрээр явуулж болно.

5.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222 дугаар хэсгийн 222.1-д заасны дагуу зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Хорих ял эдлүүлэх албатай гэрээ байгуулсан төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж болно.

5.7. Хоригдогчийн сэтгэл зүйд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц сэдэлжүүлэх сургалтын арга, аргачлалыг туршихыг хориглоно.

5.8. Сэтгэл зүйч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 216, 217 дугаар зүйл, “Хорих ангийн дотоод журам”-ын 20.2 дахь хэсэгт заасан хоригдлыг хөдөлмөрт гаргахыг хориглох, гадна хөдөлмөрлүүлэх, чөлөө олгох тохиолдолд сэтгэл зүйн тодорхойлолтыг харгалзана.

5.9. Сахилгын зөрчил гаргасан хоригдогчийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах зорилгоор тохирох сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч энэ талаар баримтжуулан холбогдох албан тушаалтанд танилцуулна.

5.10. Хоригдогчийн сэтгэл санаа тогтворгүй болж улмаар сэтгэл зүйн өөрчлөлт илэрсэн тохиолдолд эмч, эмнэлгийн ажилтантай хамтран дүгнэлт гарган ангийн удирдлагад танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.11. Амиа хорлох болон эрсдэлт зан үйл гаргаж болзошгүй болон гав, хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл хэрэглэх шаардлагатай хоригдогчийн талаар сэтгэл зүйн дүгнэлт гарган ангийн удирдлагад танилцуулна.

5.12. Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдогчийн судалгааг гаргаж ангийн удирдлага болон гүйцэтгэх ажилтанд заавал танилцуулна.

5.13. Сэтгэл санаа тогтвортой, зан үйлийн эрсдэл бага, сэтгэл зүйн тулгамдсан асуудал багатай хоригдогчтой улиралд нэг удаа ганцаарчилсан уулзалт зохион байгуулан тэмдэглэл хөтөлнө.

5.14. Сэтгэл зүйч нь хүсэлт гаргасан алба хаагчид сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлж болно.

Зургаа. Тэмдэглэл, мэдээллийн сан

6.1. Сэтгэл зүйч дараах тэмдэглэл, судалгааг гаргаж хоригдогчийн мэдээллийн санд баяжилт хийсэн байна.

- 6.1.1. Сэтгэл зүйн зөвлөгөөний хуудас /гэрээ/;
- 6.1.2. Анхны ярилцлагын тэмдэглэл;

- 6.1.3. Уулзалтын тэмдэглэл;
- 6.1.4. Холбон зуучлах хуудас;
- 6.1.5. Хоригдогчийн гэр бүлтэй хамтран ажилласан бүртгэл;
- 6.1.6. Сэтгэл зүйн тодорхойлолт;
- 6.1.7. Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдогчийн судалгааг улирал бүр гаргах /загварын дагуу/;
- 6.1.8. Зөрчил гаргасан хоригдогчтой уулзсан талаарх тэмдэглэл;
- 6.1.9. Сэтгэл зүйн дүгнэлт;
- 6.1.10. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдах хоригдогчийн судалгаа гаргах;

6.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 207 дугаар зүйлийн 207.4-д зааснаар 14 хоногийн хугацаанд хоригдлын анхан шатны судалгааны үр дүнг нэгтгэн тодорхойлолтыг гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.


6.3. Сэтгэл зүйч нь “Хоригдогсдын бүртгэл хяналтын нэгдсэн систем”-д хоригдогчийн сэтгэл зүйн тодорхойлолтыг тухай бүр оруулна.

6.4. Сэтгэл зүйн хувьд зэрэг, сөрөг өөрчлөлтөд орсон тохиолдолд хоригдогчийн өөрчлөлтийг үнэлж тодорхойлно.

6.5. Сэтгэл зүйч нь хоригдлын суллагдахын өмнөх сэтгэл зүйн тодорхойлолтыг тухай бүр гаргах бөгөөд хүний тоо бүртгэлийн ажилтан хүлээн авч хувийн хэрэгт хавсаргана.

Хорих ял эдлүүлэх алба
Маягт №1

ШШГЕГ-ын даргын 2019 оны 06 дугаар
сарын 07-ны өдрийн А/10 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ
ХУУДАС /ГЭРЭЭ/

... он ... сар ... өдөр

Улаанбаатар хот

Сэтгэл зүйн үйлчилгээний төрөл: Сэтгэл зүйн зөвлөгөө авах;

Сэтгэл зүйн зөвлөгөөг авч болох хэлбэр: Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө;

Сэтгэл зүйн зөвлөгөөний онцлог:

Хоригдогчид тулгарсан асуудлаас үүдэлтэй зан үйл, бодлуудыг эерэгээр өөрчлөхөд туслах, нөхцөл байдлыг бодитоор хүлээн авч, түүнийг даван туулахад сэтгэл зүйчтэй хамтран ажиллана.

Сэтгэл зүйн зөвлөгөөний зорилго:

Бие хүн, гэр бүлийн харилцаанд үүсч буй асуудал болон орчноос шалтгаалсан сэтгэл зүйн асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. Сэтгэл зүйн зөвлөгөөний гол зорилтууд:

- Хоригдогч асуудлаа шийдвэрлэх арга замуудыг сэтгэл зүйчийн тусламжтайгаар олж мэдэх;
- Хоригдогч тухайн сэтгэл зүйн асуудлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгөх;
- Сэтгэл зүйн хямралаас урьдчилан сэргийлэх зөв ойлголттой болох;

Сэтгэл зүйн зөвлөгөөний үр дүн:

- Сэтгэл зүйн тогтворгүй байдал, сэтгэл санаа хямрах, бухимдах зэрэг шинжүүдийг бодитойгоор ухамсарлаж, засаж өөрчлөх сэдлийг хоригдогчид төрүүлнэ.
- Хүсээгүй зан үйлд хүргэж байгаа өөрийн бодол ба мэдрэмжээ танин мэднэ.
- Хүсээгүй зан үйлийн зөрөг сөрөг үр дагаварыг бодож ухамсарлаж сурна.

Үргэлжлэх хугацаа: Хоригдогчийн сэтгэл зүйн асуудлаас хамааран сэтгэл зүйн зөвлөгөөний уулзалтыг хязгаарлахгүй.

Нууцлал: Өгсөн мэдээллийг сэтгэл судлаачийн ёс зүйн хүрээнд чандлан нууцлах, хамтран ажиллах яриа өгүүлэл зэргийг нууцлах үүргийг хүлээнэ.


Үүрэг: хамт ял эдлэж буй хоригдогчид учирч буй сэтгэл зүйн саад бэрхшээлийн талаар сэтгэл зүйчид хамтран ажиллах хүсэлтийг тавих буюу зуучилж өгч болно.

Зөвшөөрлийн хуудас:

Миний бие _____ овогтой _____ сэтгэл зүйн зөвлөгөөнд сайн дураар оролцохыг хүсч, баримталбал зохих дүрэм журмыг мөрдөн, өөрийн болон бусдын сайн сайхны төлөө өөрчлөлт хийхийг хүсч байгаагаа илэрхийлж байна.

СЭТГЭЛ ЗҮЙЧ /

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:
ГАРЫН ҮСЭГ /



АНХНЫ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

..он..сар..өдөр

Овог Нэр:

1. Гэр бүлийн намтар

1.1. Одоогийн гэр бүлийн байдал, харилцааны талаар хэлнэ үү.

- Гэр бүлтэй хамт амьдардаг
- Салсан /салаад хэдэн жил болж байгаа/ ...
- Тусдаа амьдардаг
- Гэр бүлийн хүн нас барсан
- 2-оос дээш удаа гэр бүл зохиосон
- Гэрлээгүй, ганц бие

1.2. Гэр бүлийн зөрчил маргаан байсан уу, үнэлвэл:

- Их
- Дунд
- Бага
- Байгаагүй

1.3. Бага нас, өсвөр насны гэр бүлийн байдал

- Бага насандаа эцэг эхтэйгээ өссөн
- Эмээ өвөө дээр өссөн
- Бага насанд эцэг салсан
- Асрамжийн газар өссөн
- Бүтэн өнчин

1.4. Гэр бүлийн зөрчил, маргаан байсан уу? үнэлвэл

- Их
- Дунд
- Бага
- Байгаагүй

1.5. Боловсролын талаар: / суралцахад бэрхшээл байсан эсэх/

- Дээд
- Бүрэн дунд
- Бүрэн бус дунд
- Тусгай дунд
- Бага
- Боловсролгүй
- Шалтгаан

2. Ажил, хөдөлмөр эрхлэлтийн талаар:

.....
.....

3. Ямар нэгэн суурь өвчин, зовиур байна байна уу? Энэ байдал хэр удаан хугацаагаар үргэлжилж байгаа вэ?, Одоогоор ямар нэгэн эм, тариа хийлгэж байгаа эсэх,

.....
.....

4. Хорт зуршилтай эсэх /хариултыг тэмдэглэх/

- Согтууруулах ундаа 0-5 жил 5-10жил 10-20 жил 20-сдээш жил
- Мансууруулах бодис 1-3 жил 4-6 жил 7-10 жил 10-сдээш жил
- Тамхи 0-5 жил 5-10жил 10-20 жил 20-сдээш жил
-

Эрүүлжүүлэгдэж, саатуулагдаж байсан эсэх

5. Сэтгэл зүйн үнэлгээний асуултууд

1. Таны нойр ямар байна вэ?

- Хэвийн
- Хэт их унтаж байгаа
- Нойр хүрэхгүй байгаа
- Унтаж байгаад сэрдэг

2. Хоол идэх хүсэл ямар байна вэ?

- Их идэж байгаа, цадсан мэдрэмж авахгүй байгаа
- Хэвийн идэж байгаа ч цадсан мэдрэмж авахгүй байгаа
- Бага идэж байгаа хэрнээ цадсан мэдрэмж авч байгаа
- Хоол идэх хүсэл төрөхгүй байгаа

3. Та ирээдүйг яаж харж байна вэ?/ итгэл найдвартайгаар, гутрангүй, өөдрөг/

- Ирээдүйн талаарх төсөөлөлтэй
- Төсөөлөл бүдэг
- Төсөөлөл байхгүй

4. Өөрийгөө гэмтээх болон амиа хорлох талаар бодож байсан эсэхийг тодруулах асуулт:

- Бие дээр аваар осолын болон гэмтэл бэртэл авч байсан шарх сорвитой юу?
- Тийм /тийм бол нарийвчлан асууж ярилцлагын хуудасанд тэмдэглэл хийх/
- Үгүй

5. Ямар нэгэн дуу чимээ, эсвэл хэн нэгний хоолой сонсогдож байсан уу. /хий юм харж байсан уу/

- Тийм /тийм бол нарийвчлан асууж ярилцлагын хуудасанд тэмдэглэгээ хийх/
- Үгүй

6. Өөрийг чинь хэн нэгэн хянах эсвэл оюун санааг чинь өөр хүн удирдаж байгаа юм шиг мэдрэмж төрж байна уу

- Тийм /тийм бол нарийвчлан асууж ярилцлагын хуудасанд тэмдэглэгээ хийх/
- Үгүй

7. Та ямар нэг зүйлд анхаарал төвлөрч, ойлгож чадаж байна уу.

- Тийм
- Үгүй

8. Биеийн хэлэмж:

.....

9. Хувийн хэрэгтэй танилцсан мэдээлэл:

.....


ДҮГНЭЛТ

.....

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: / /

Хорих ял эдлүүлэх алба
Маягт №3

ШШГЕГ-ын даргын 2019 оны 06 дугаар
сарын 04-ны өдрийн А/10 дүгээр тушаалын
хөёрдугаар хавсралт



УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

...он..сар..өдөр

Овог Нэр

Ярилцлагын тэмдэглэл:

.....
.....

Ажиглалтын явц /биеийн хэлэмж/:

.....
.....

Сэтгэл хөдлөлийн байдал:

.....
.....

Одоогийн тулгамдсан асуудал:

.....
.....

Сэтгэл зүйчийн зүгээс санал болгосон зөвлөмж, зөвлөгөө:

.....
.....

Хүлээн авсан байдал:

.....
.....

Дүгнэлт:

.....
.....

Давтан уулзалт шаардлагатай эсэх:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: /

ХОЛБОН ЗУУЧЛАХ ХУУДАС


д/д	Овог Нэр	Зүйл анги	...он..сар..өдөр
Хоригдогчийн хэрэгцээ, шаардлага			
Сэтгэл зүйн байдал			
Хүсэж буй үйлчилгээ			
Үйлчилгээ үзүүлсэн албан тушаалтан	Хүлээн авах албан тушаалан		

БУЦАХ ХУУДАС

д/д	Овог Нэр	Хүлээн авсан ...он..сар..өдөр	Буцаасан ...он..сар..өдөр
Үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэл			
Бусад			
Хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн албан тушаалтан	Танилцсан албан тушаалтан		

Хорих ял эдлүүлэх алба
Маягт №5

ШШГЕГ-ын даргын 2019 оны 06. дугаар
сарын 07-ны өдрийн А/10 дүгээр тушаалын
хөёрдугаар хавсралт




ХОРИГДОГЧИЙН ГЭР БҮЛТЭЙ ХАМТРАН
АЖИЛЛАСАН БҮРТГЭЛ

№	Овог нэр	Хэн болох	Гэр бүлийн гишүүний нэр	Ярилцлагын товч утга	Гэр бүлийн гишүүний гарын үсэг	Он сар өдөр

Жич: Хоригдогчийн сэтгэл санаа тогтворгүй, сэтгэл зүйн өөрчлөлт ажиглагдах болон гэр бүлийн гишүүдээс сэтгэл зүйн дэмжлэг авах болон мэдээлэл солилцоход тус бүртгэлийг ашиглаж баримтжуулна.

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН: /

/



..... ОВОГТОЙ ХОРИГДОГЧ
СЭТГЭЛ ЗҮЙН ТОДОРХОЙЛОЛТ

...он..сар..өдөр

Улаанбаатар хот

1. Анхны ярилцлагын үеэр гэр бүлийн харилцаа, цаашдын хандлагаа үнэлж, тодорхойлсон байдал
2. Сэтгэл зүйн сорил тестэд хамрагдсан талаарх мэдээлэл
3. Судалгааны үр дүнг бичих
4. Ажиглалтын явцад илэрсэн нөхцөл байдлын талаар
5. Зан үйл гарч буй өөрчлөлт
6. Цаашид анхаарах зүйлс
7. Сургалтад хамрагдсан талаар
8. Дүгнэлт, санал зэргийг багтаасан байна.

ТАНИЛЦСАН: /

ТОДОРХОЙЛСОН: /

СЭТГЭЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛТАЙ
ХОРИГДОГЧИЙН СУДАЛГАА

...он..сар..өдөр

Улаанбаатар хот

№	Зураг	Овог нэр	Зүйл анги	Сэтгэл зүйн онцлог /судалгааны үр дүн/	Эрсдэлт зан үйл /Тодорхойлон бичих/	Харилцах арга барил
Сэтгэцийн өөрчлөлттэй байж болзошгүй хоригдол						
Сэтгэл гутралд орох эрсдэлтэй хоригдол						
Амь биеэ эрхтэндээ гэмтэл учруулж болзошгүй хоригдол						
Гэмт хэргийн байдлаа хүлээн зөвшөөрөөгүй улмаас эрсдэл гаргаж болзошгүй хоригдол						
Сэтгэл санаа тогтворгүй хоригдол						

ТАНИЛЦСАН:


СУДАЛГАА ГАРГАСАН:

/

/

Хорих ял эдлүүлэх алба
Маягт №8

ШШГЕГ-ын даргын 2019 оны 06 дугаар
сарын 07-ны өдрийн А/10 дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



ЗӨРЧИЛ ГАРГАСАН ХОРИГДОГЧТОЙ
УУЛЗСАН ТЭМДЭГЛЭЛ

...он..сар..өдөр

Улаанбаатар хот

..... овогтой нь ЭХ-н..... зүйл
ангиар жил сар удаагийн ял шийтгэлтэй.


.....сахилгын
зөрчил гаргасан тул
сахилгын шийтгэл оногдуулсан тул зөрчил гаргасан шалтгаан нөхцөл болон сэтгэл зүйн
онцлогийг харгалзан

.....
.....
.....
.....
сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн болно.

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН		
СЭТГЭЛ ЗҮЙЧ..... /		/
ҮЙЧИЛГЭЭ АВСАН..... /		/

Хорих ял эдлүүлэх алба
Маягт №9

ШШГЕГ-ын даргын 2019 оны 06 дугаар
сарын 07-ны өдрийн А/М дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



.....ОВОГТОЙ ХОРИГДОГЧ.....
СЭТГЭЛ ЗҮЙН ДҮГНЭЛТ

...он..сар..өдөр

Улаанбаатар хот

1. Сэтгэл зүйн хувийн онцлог
2. Одоогийн сэтгэл зүйн байдал
3. Эрсдэлт зан үйлийн илрэл
4. Цаашид анхаарах сэтгэл зүйн тулгамдсан асуудал болон илэрч болзошгүй зан үйлийн илрэлийн талаарх мэдээллийг багтаасан байна.
5. Санал

ТАНИЛЦСАН: /

ДҮГНЭЛТ ГАРГАСАН: /